

Төрийн хэлбэрийн тухай Платон,Аристотель нарын үзэл

Доктор Г.Эрдэнэбаяр.

Түлхүүр үгс.Төр,төрийн зарчим,төрийн хэлбэр,хаантан-философич.

Төр хэмээх ойлголт нь улс төрийн философийн үндсэн ойлголт юм. Төрийн тухай асуудал нь нийгмийн бүхий л үед философич, улс төр судлаачдын анхаарлыг татаж ирсэн нарийн төвөгтэй асуудал билээ. Хүн төрөлхтөн байгаль орчноо танин мэдэж амьдралын түвшин нь дээшлэн мэдлэгийн цар хүрээ өргөжихийн хирээр амьдарч буй нийгмээ төлөвшүүлэх явдал амар тайван амьдралын үндэс нь төр гэдгийг ойлгох болсон. Энэ цаг үеэс өнөөг хүртэл төр нь эрин зууныг дамжин боловсронгуй болон хөгжсөөр өнөөгийн ардчилсан төрийн тогтолцоонд шилжиж байна. Нийгмийн хөгжлийн явцад асар их өөрчлөлтүүд гарч төр, түүний үүсэл, мөн чанар, үүрэг, ач холбогдлыг ойлгох ойлгоц өөрчлөгдөж иржээ.

Улс төрийн философийн түүхэн хөгжлийн явцад “Төр гэж юу вэ?” гэсэн асуудалд олон янз хариу өгч, янз янзаар тодорхойлон тайлбарласаар ирсэн байна. Төрийн тухай үзэл сургаалыг эртний Грекийн философич Пифагор, Гераклит, Демокрит,Сократ, Платон, Аристотель нараас эхлүүлэн авч үзсэн бөгөөд тэдний нилээд хэсэг нь төрийг шударга ёс, эрх, эрх чөлөө, нийгэм, байгалийн хөгжил хөдөлгөөн гэж үзэн, төрийг хууль, улс төр, иргэнтэй холбон тайлбарлаж байв. Философийн түүхээс үзвэл төрийн үүслийн тухай асуудал онцгой байр суурь эзэлж байсан бөгөөд төрийн хэлбэр, түүхэн хэв маяг нь түүний мөн чанартай холбогдож, улс орныг хэн захирч байна вэ? гэсэн асуултанд тулгуурлаж байв.Төрийг хэн захирах ёстой вэ? гэдэг бол улс төрийн философийн чухал асуудлын нэг байв.

Эртний Грект энэхүү асуудлын онолын үндэслэлийг боловсруулсан гол төлөөлөгчид нь Платон, Аристотель нар юм. Эртний Грекийн философич Платон¹⁰ / МЭӨ 427-347 / өөрийн философийн сургаалийн цөм болох “Эйдос-ын” онолдоо тулгуурлан, нийгэм улс төрийн үзлээ боловсруулсан байдаг. Тэрээр “Төр улс” хэмээх томоохон зохиол болон “Хуулиуд” хэмээх зохиолыг бүхэлд нь нийгэм улс төрийн асуудалд зориулжээ. Мөн түүний “Улс төрийн бодлого” хэмээх алдартай зохиол ч бий. Эдгээр бүтээлдээ нийгэм улс төрийн асуудлыг зарим талаар харилцан адилгүй байр сууринаас авч үзэж боловсруулжээ. Тэрээр “Төр улс” зохиолдоо асуудлыг эйдосын онолын үүднээс тайлбарлажээ.

Платон хүний нийгмийн түүхэнд олон нийгэм төрийн байгууллууд бие биеэ халж сольж ирсэн ба энэ бүх үеийн туршид төрийн байгуулал нь нэгээс нөгөөд шилжихийн хамт уруудан доройтож ирсэн гэж үзэж байв. Төрийн байгууллын сөрөг хэлбэрээс өмнө “Хроносын” нийгэм оршиж байсан. Энэ нь хүн төрөлхтний нийгмийн алтан үе юм. Энэ цаг үед хүмүүс нийгмээрээ хамтран аж төрж байгаль эхтэйгээ шууд харилцаж байлаа. Тэр үед хүн байгалийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг нь байж дотор нь аж төрж байв. Мөн тэр үед хүнд элдэв илүү хэрэгцээ байсангүй. Тийм учраас хүмүүс бололцоо ихтэй, тэрхүү бололцоогоо

¹⁰ Р.Дарьхүү.Г.Эрдэнэбаяр.Философийн түүх.УБ.,2004.134-135 дах тал

гол төлөв философийг судлах, эзэмшихэд зориулдаг байжээ. Энэ үеэс хойш нийгэм хөгжихийн хэрээр хүн байгалиас тасарч, хөндийрчээ. Тэр хирээр хүний элдэв илүү хэрэгцээ улам бүр нэмэгдэх болжээ.. Чухам тийм учраас нийгмийн амьдрал улам бүр доройтсоор байгаа юм. Энэхүү Хроносын эринг өнөөдөр сэргээж босгох, хүний нийгмийн шилдэг хэв загвар болгон тусгаж болохгүй гэж Платон үзэж байв. Түүний үзлээр, төрийн хамгийн зохистой хэлбэр нь аристократ /aristocracy/ төр бөгөөд Хроносын эринээс хойш төрийн дараах сөрөг хэлбэрүүд гарч ирсэн. Үүнд:

1. Тимократи / timocracy /. Энэ бол нэр төрд дурлагчдын үе. Хроносын эриний эцсээс эхлээд хүмүүс байгалиас аажмаар салж тасарч ирсэн. Ийм үед хүмүүс алдар нэр, эд баялгийг шохоорхож, алт, мөнгө, эд баялгийг эрж хайх, улмаар тэдгээрийг завших болсон юм. Энэ бол тимократын үе мөн.

2. Олигархи / oligarchy /. Энэ бол цөөнх ноёрхдог төрийн хэлбэр юм. Тимократын үед ихээхэн эд баялаг хуримтлуулсан цөөнх нь нийгмийг захирах болсон үе юм.

3. Ардчилал / democracy /. Энэ нь хүн амын олонхи нь цөөнхийг захирах хэлбэр болно.

4. Хаант засаг / tyranny /. Энэ нь нэг хүн олонхийг (нийгмийг) захирах хэлбэр эдгээр болно. Хүний нийгмийн түүхэнд эдгээр хэлбэрүүд бие биеэ ээлжлэн халж сольж иржээ. Ийнхүү Платон "Төр улс"¹¹ хэмээх бүтээлийнхээ наймдугаар номонд төрийн таван үндсэн хэлбэрийг авч үзсэн буй.

Төрийн сөрөг хэлбэрийн үндсэн гол алдаа бол нийгмийн амьдралын үндсэн зарчим нь зөрчигдсөн явдал гэж Платон дүгнэсэн буй. Тэрхүү зарчим нь нийгмийн аливаа гишүүд өөрийн чадах зүйлээ л хийх ёстой гэсэн хууль юм. Төрийн сөрөг хэлбэрүүдийн үед энэ зарчмыг хайхардаггүй болсон. Гуталчин төр барих жишээтэй болжээ. Тийм учраас хүн өөрөө чадахгүй байсан ч гэсэн бүгд төрийг удирдах гэж зүтгэцгээх болсон. **Хүн бол угтаа чадах зүйлээ л хийх ёстой. Энэ тун чухал санаа юм.**

Платоны үзлээр, Нийгэм хамгийн зүй зохистойгоор оршин тогтнож хөгжихийн тулд дараах социал бүтэцтэй байх нь тохиромжтой. Үүнд:

- Үйлдвэрлэн бүтээгчид. Энэ бол малчид, тариачид, гар урчууд юм. Тэдний дотор эрхлэх ажлын нарийвчилсан хуваарь байна. Тэд бол нийгэм оршин тогтнох үндэс болсон материал баялгийг үйлдвэрлэн бүтээнэ. Тэд бүр юм бүхнийг үйлдвэрлэх биш, харин хамгийн сайн чадах тэр зүйлээ л хийх ёстой. Тийм учраас энд нийгэм дутах гачигдах юмгүй болно. Тэдний хийсэн бүтээснийг бусдад хүргэж энд тэнд борлуулж байдаг худалдаачид мөн энэ давхрагад хамаарна. Энэ бол нийгмийн зохион байгуулалтын доод шат нь юм.
- хоёрдугаарт, цэрэг шүүхийнхэн байх ёстой. Хүн байгалиас асар их салж холдсон үед дайсагнагчгүй нийгэм гэж байхгүй болсон. Тийм учраас аливаа нийгэм оршин тогтнохын тулд нийгмийн харилцааг зохицуулах анги зайлшгүй чухал юм.
- нийгмийг удирдагч жолоодогчийн анги байх ёстой ажээ. Энэ бол философичид юм.

Платон философичид нийгмийг удирдах ёстой, философичид хаан байх ёстой гэж үзэж байв. Өөрөөр хэлбэл, түүний үзлээр, мэргэн ухаантай нь оройлон захирч, учир мэдэхгүй нь тэдний араас дагах ёстой. Энд хариуцлагатай улс төрч бол аливаа шинжээчээс илүү үнэн болоод цэцэн билгийг эрхэмлэдэг, өөрийнхөө мөхөсийг мэдэх чинээний ухаантай байх ёстой хэмээх Сократын зарчмыг Платон уламжилсан болно. Сократ бол Платоны багш бөгөөд төрийн зүтгэлтнийг эрх мэдэл, гарамгайлал, мэргэн ухаандаа аархан толгой нь эргэхээс сэрэмжлүүлж байжээ.

¹¹ Платон. Төр улс. УБ., 2005. 195-196 дах тал.


Түүний энэхүү баримтлалыг хожим К.Поппер шүүмжилсэн буй.К.Поппер хэлэхдээ: "Платон улс төрийн асуудлыг "Хэн захирах ёстой вэ" буюу "Хэний хүсэл зориг ноёлох вэ" гэх мэтийн асуулт хэлбэрээр тавьснаар улс төрийн философийг урт удаан хугацаанд будилуулсан гэдэгт би огт эргэлзэхгүй байна"¹² гэжээ. Платоны төрийн тухай онол нь ерөнхийдөө тоталитари хандлагатай үзэл хэмээн К.Поппер шүүмжилсэн юм.

Эртний Грекийн философич их Аристотель(МЭӨ 384-322)төр,түүний мөн чанар,хэлбэрийн асуудлыг онцлон авч үзэж байв.Түүний үзлээр,төр бол хүмүүсийн хамтран амьдрах дээд хэлбэр,иргэдийн нийтлэг эрх ашгийг илэрхийлэх чадвартай байгууллага юм.Тэрээр нийгэм улс төрийн асуудлыг, нэг талаас уг асуудлаархи тухайн үеийнхээ онол сургаалийг шүүмжлэх, нөгөө талаас бодит оршин буй нийгмийн олон талт харилцааг шинжлэн дүгнэх тал дээр анхаарч байлаа. Аристотель нь Грекийн 158 хот улсын үндсэн хуулийг цуглуулж системтэй судлаж байсан тухай мэдээ бий. Түүнд 1890 онд "Афины Полити" гэдэг зохиол олдсон байна.

Нийгэм, улс төрийн асуудлыг Аристотель юуны өмнө боолын нийгмийн харилцааг задлан шинжлэхээс эхэлсэн байдаг. Энэ бол тэр үеийн бүх хот, улсууд боол эзэмшлийн үйлдвэрлэл дээр шууд суурилж байсантай холбоотой.Хүний сүнс хийгээд бие хоёр, хүн хийгээд адгуус хоёр хоорондоо их ялгаатай байдгийн адил, боол боолын эзэн хоёр хоорондоо тийм ялгаатай байдаг гэж Аристотель боолчлолын асуудлыг тухайн үеийнхээ эдийн засгийн системтэй холбон үзжээ.

Түүний үзлээр, амьдралын эн тэргүүний хэрэгцээт зүйлүүдгүйгээр хүн амьдрах бололцоогүй. Тэр өөрсдөө буй болохгүй. Тийм учраас боолын хөдөлмөр зайлшгүй юм. Боол бол өрх гэрийн өмчийн нэг хэсэг буюу "ярьдаг зэвсэг" хэмээн тодорхойлсон байдаг. Боол бол ямарваа бие даасан сэтгэлгээгүй бөгөөд зөвхөн бусдын захиран тушаасныг хүлээн авч, биелүүлж чаддаг хүн юм. Биеийн бүтцийн хувьд ч өөр зориулалттай байна. Боол бол төрөлхийн чанга биетэй тул дан ганц биеийн хөдөлмөрт зориулагдсан байдаг. Чөлөөт иргэд бол оюун санаа нь хөгжсөн байдаг. Тэд бол улс төрийн амьдралд зориулагдсан. Боолчууд төрийн бүтцэд ч орохгүй. Төр бол хүмүүсийн хоорондын харилцааны нэг хэлбэр юм.Хүн бол улс төрийн амьтан.

Төрийн бүтэц бол нарийн нийлмэл үзэгдэл.



Эдгээрээс төрийн бүтцэд цэргийнхэн, хууль тогтоогчид гэсэн үндсэн хоёр анги байна.

Түүнчлэн, нийгэмд олон янзын ангиуд байх бөгөөд аль ч нийгэмд үндсэн хоёр анги байна. Нэг нь баячууд, нөгөө нь ядуучууд. Төрийн ямар ч хэлбэрийг авч үзсэн эцсийн дүндээ энэ хоёрын аль нэг нь л байдаг. Асуудлын гол нь энэ хоёр ангийг биш, тэдний нэг дунджийг бий болгох ёстой гэж Аристотель үзжээ. Энэ бол боол, боолын эзэн хоёрын дундаж биш юм. Чөлөөт иргэд бол дотроо

¹² К.Поппер.Нээлттэй нийгэм,түүний дайснууд.УБ.,2006.123 дах тал.

хоёр янз байна. Хэт баячууд, хэт ядуучууд гэж бий. Дундаж анги гэдэг бол энэ хоёрын дундаж юм. Зөвхөн ийм хүн л төрийг удирдах боломжтой болдог.

Төрийн эрх баригчид засгийн өмнө ямар зорилго тавьж байгаагаас шалтгаалан Аристотель төрийн засаглалын зохистой ба зохисгүй хэлбэрүүдийн талаар өөрийн онолоо дэвшүүлжээ. Түүний үзлээр, төрийн засаглалын хамгийн зохистой хэлбэр нь полити төр юм. Харин төрийн засаглалын зохисгүй хэлбэр нь тиран болно. Учир нь тиран бол амин хувийн сонирхол ямагт нийтийн эрх ашгаас доогуур тавигдах учиртай гэж үздэг байна.

Тэрээр төрийн засаглалын гурван үндсэн хэлбэрийг авч үзжээ. Үүнд: ганцаар захирах засаг, цөөнх захирах засаг, олонхи захирах засаг багтана. Эдгээр хэлбэрийг жам ёсоор бий болгож чадвал эдгээрийн аль нь ч гэсэн төрийн засаглалын шилдэг хэлбэр байж болно. Жам ёсоор нь буй болгож чадахгүй бол аль нь ч муу засаглал болон хувирч чадна.

Монархи (monarchy) бол эзэн хаант засаг, нэг хүний захирах хэлбэр юм. Энэ хэлбэрийн үед төр, эзэн хаан нь нийт нийгмийн эрх ашгийг удирдлага болгосон байдаг. Аристократи төр бол цөөнхий засаг. Цөөнх нь нийт нийгмээ төлөөлж тэдний төлөө засаглаж байгаа хэлбэр юм. Полити бол олонхийн засаглал. Сүүлийн хоёрыг олонхи, цөөнх гэдгээр ялгаж байна. Амьдрал дээр энэхүү олонхи гэдэг бол хэзээд ядуучууд байдаг ажээ. Цөөнх нь баячууд байдаг. Энэ утгаараа аристократи бол баячуудын засаг. Полити бол ядуучуудын засаг гэж хэлж болно. Аристотель эдгээр хэлбэрүүд дотроос олонхийн засаглалыг шилдэг хэлбэр нь гэж үзсэнээрээ Платоны эсрэг үзлийг баримтлагч юм. Учир нь энэ политийн үед л нийгэмд тэрхүү дундаж анги ноёрхох бололцоотой болдог. Энэ үед нийгэмд хэт баячууд ч биш, хэт ядуучууд ч биш, завсрын хүчин ноёрхож байдаг гэжээ. Мөн түүний үзлээр, төрийн засаглалын өөр гурван хэлбэр байна. Үүнд: тиран, олигархи, ардчилал болно.

Тиран бол эзэн хаант засаглал юм. Энэ хэлбэрийн үед эзэн хаан зөвхөн өөрийнхөө эрх ашгийг удирдлага болгосон байдаг. Олигархи бол цөөнхийн засаглал мөн. Энэ үед нийт нийгмийг зөвхөн энэ цөөнхийн эрх ашигт захируулдаг. Ардчилал бол олонхи ноёрхож, олонхийн эрх ашгийг цөөнхид сөргүүлэн тавьдаг төрийн засаглалын зохистой хэлбэр юм.

Эцэст нь дүгнэвэл, Платоны хувьд олонхий засаглалын эсрэг элитийн онолыг үндэслэгч бол, Аристотелийн хувьд олонхийн засаглалын онолыг баримтлагч юм.

Ном зүй.

- Антология мировой философии /античность/ М., 2001
- С.Р.Аблеев. История мировой философии. М., 2002
- В.Ф.Асмус. Античная философия. М., 2003
- Богомолов.В. Античная философия. М., 1992
- Великие мыслители запада. М., 1999
- Гуннар Скирбекк, Нилс Гилье. История философии. М., 2003
- Р.Дарьхүү, Г.Эрдэнэбаяр. Философийн түүх. УБ., 2004.
- История философии. т I. М., 1940
- К.Поппер. Нээлттэй нийгэм, түүний дайснууд. УБ., 2006.
- Платон. Төр улс. УБ., 2005.
- Б.Рассел. История западной философии. Новосибирск., 1999
- B.N.Moore.K.Bruder. Philosophy. USA. 5th ed. 2002